“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТ

# АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

2017 ОН

Агуулга

Аудитын нэр ....................................................................................................................................2
Аудитын код ....................................................................................................................................2
Аудит хийх бүрэн эрх, үндэслэл..................................................................................................2
Аудитын зорилт...............................................................................................................................2
Хамрах хүрээ ....................................................................................................................................2
Үндсэн мэдээлэл...............................................................................................................................2
Эрсдэлийн үнэлгээ ..........................................................................................................................3
Аудитын арга зүй ............................................................................................................................3
Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт ...............................................................4
Аудит хийх хугацаа..........................................................................................................................4
Аудит хийх багийн бүрэлдэхүүн ...................................................................................................4
Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгаглах мэдээлэл, хэлэлцүүлэх журам ..........................5
Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц ...............................................................................................5

БАТЛАВ. МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР Д.ХҮРЭЛБААТАР

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

**Аудитын нэр**
"Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагаа

**Аудитын код**
ҮАГ-ГАГ/2017/11-ГА

**Аудит хийх бүрэн эрх, үндэслэл**

Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2017 оны 2 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийнэ.

**Аудитын зорилт**

"Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг шалгаж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтан болон Улсын Их Хуралд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр */асуудлын шинжилгээг хавсралт №2-т үзүүлэв/* аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- "Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газар хууль, эрх зүйн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа эсэх;
- "Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газар чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх

**Хамрах хүрээ**

Аудитыг "Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2013 оноос 2017 оны эхний хагас жил хүртэлх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэлд үндэслэн "Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газар болон тус үйлдвэрийн газраас Улаанбаатар хот, Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Увс, Ховд, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Баянхонгор, Сүхбаатар аймгуудад хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийг хамруулан шалгана.

**Үндсэн мэдээлэл**

"Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газрыг Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, төрөөс иргэдийг орон сууцаар хангах ажлыг эрчимжүүлэх зорилгоор Засгийн газрын 2013 оны 253 дугаар тогтоолоор үүсгэн байгуулсан.

Байгууллагын үйл ажиллагааны үндсэн чиг үүргийг "Хүн амыг хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, төрөөс зорилтот бүлгийн иргэдийг орон сууцаар хангах, хөнгөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх" гэж тодорхойлсон бөгөөд энэ хүрээнд дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:



"Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газар нь 2017 оны эхний хагас жилийн байдлаар 124.3 тэрбум төгрөгийн авлага, 353.1 тэрбум төгрөгийн өр төлбөртэй.

Үүнээс богино хугацаат өр төлбөр 68.8 тэрбум төгрөг, урт хугацаат өр төлбөр 284.3 тэрбум төгрөг байна.

Нийслэл болон орон нутагт нийт 212.8 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 29 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаагаас 13 төсөл, арга хэмжээнд цэвэр санхүүжилт олгох хэлбэрээр, 16 төсөл, арга хэмжээ барилгын хөрөнгө оруулалт байдлаар хэрэгжүүлж байна.

**Эрсдэлийн үнэлгээ**

Төлөвлөлтийн үе шатны явцад судалсан баримт, материал, судалгаанд хийсэн урьдчилсан дүн, шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн "Төрийн орон сууцны корпораци" Төрийн өмчит үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнд хийх аудитын эрсдэлийн үнэлгээг "Дунд" гэж үзлээ. */Эрсдэлийн үнэлгээг хавсралт №1-д үзүүлэв/*

**Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журам болон гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/-ийг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, судалгаа, тайлан зэрэг баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, орон нутаг дахь зарим төрийн аудитын байгууллагыг татан оролцуулах, Монгол Улсын Үндэсний Статистикийн хороо болон бусад судалгааны, үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагатай хамтран ажиллаж, орон сууцны зах зээл, үнийн судалгааг авах, "ТОСК" ТӨҮГ-аас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд ашиглалтад ороогүй барилга, байгууламж холбогдох стандарт, норм, дүрмийн дагуу баригдсан эсэхийг шалгаж, дүгнэлт гаргах асуудалд хөндлөнгийн шинжээч ажиллуулах зэрэг арга зүйг ашиглахын зэрэгцээ аудитын судалгаа, хөтөлбөрийн дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсруулна. */Аудитын арга зүйг хавсралт №3-д үзүүлэв/*

Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Увс, Ховд, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Сүхбаатар, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрууд асуудлын шинжилгээний 1.2.1.3, 1.2.1.4-т тусгасан асуудлыг шалган дэд тайлан бэлтгэж, нэгдсэн тайланд нэгтгүүлнэ.

Үндэсний аудитын газраас асуудлын шинжилгээний 1.2.1.2-т тусгасан асуудлаар хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа боловсруулж, судалгааг дээр дурьдсан орон нутаг дахь төрийн аудитын газрын аудиторууд оршин суугчдаас авч, нэгтгэн ирүүлнэ.

Шаардлагатай тохиолдолд Үндэсний аудитын газар, Нийслэл дэх төрийн аудитын газрын хуулийн мэргэжилтэнг аудитад ажиллуулна.

**Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт**

Дараах хууль эрхийн актыг аудитын шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглана:

- Барилгын тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Орон сууцны тухай хууль;
- Хот суурин газрын усан хангамж, ариутгах татуургын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Иргэний тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Төрийн аудитын тухай хууль;
- Авилгатай тэмцэх тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Компанийн тухай хууль;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- УИХ-ын 36 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ бүтээн байгуулалт" дунд хугацааны зорилтот хөтөлбөр;
- Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Засгийн газрын 2013 оны 253 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2013 оны 263 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2013 оны 262 дугаар тогтоол
- Засгийн газрын 2014 оны 36 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2014 оны 197 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2015 оны 117 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2015 оны 127 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2015 оны 236 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2015 оны 248 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 38 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 169 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоол

**Аудит хийх хугацаа**

Аудитыг 2017 оны 11 дүгээр сарын 20-ны өдрөөс эхэлж, орон нутаг дах төрийн аудитын газраас тайлан, судалгааг 12 дугаар сарын 22-ны өдрийн дотор хүлээн авч, нэгдсэн тайлангийн төслийг 2018 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр дуусгаж, үе шатны хяналтаар оруулан хянуулж, аудитын болон Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, 2018 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр УИХ-д хүргүүлнэ. *(Аудитын хөтөлбөрийг хавсралт №6-д үзүүлэв)*

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн**

Аудитыг Гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор М.Даваанyam удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер З.Ариунзаяа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Гандолгор, аудитор М.Туул, Э.Уянга, Н.Эрдэнэбаяр, Нийслэл дэх төрийн аудитын газрын ахлах аудитор С.Зоригт, аудитор Б.Билэгт, Архангай, Хэнтий, Сэлэнгэ, Дархан-Уул, Увс, Ховд, Орхон, Хөвсгөл, Говь-Алтай, Дундговь, Баянхонгор, Сүхбаатар аймаг дахь төрийн аудитын газрын аудиторууд төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Түүнчлэн шаардлагатай тохиолдолд Үндэсний аудитын газар, Нийслэл дэх төрийн аудитын газрын хуулийн мэргэжилтэнг аудитад ажиллуулна.

**Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам**

Аудитын тайлан нь ерөнхий зүйл, аудитын дүн, аудитын дүгнэлт, зөвлөмжтэй байхаас гадна холбогдох газрын санал, түүнд хийсэн тайлбар, хавсралт гэсэн агуулгаар бичигдэнэ.

Аудитын тайлангийн төслийг Ерөнхий аудиторын орлогчийн зөвшөөрснөөр холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулан санал авч, тайлангийн эцсийн хувилбарыг Үндэсний аудитын газрын Аудитын зөвлөлийн хурал болон Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

**Аудитад шаардагдах хөрөнгө, нөөц**

А. Боловсон хүчин:

Үндэсний аудитын газраас 8 хүн х 51 өдөр = 408 хүн/өдөр

Нэр бүхий орон нутаг дахь төрийн аудитын байгууллагаас 24 хүн х 22 өдөр = 528 хүн/өдөр

Б. Санхүүгийн нөөц:

- Цалин - Үндэсний аудитын газар 8 хүн*64.0 мян.төгрөг* 51 өдөр = 26.1 сая төгрөг,
  Орон нутаг дахь төрийн аудитын газар 24 хүн*22 өдөр=33.8 сая төгрөг
- Хөндлөнгийн шинжээч ажиллуулахад нийт 20.0 сая төгрөг
- Бичиг хэрэг - 500.0 мянган төгрөг

В. Техник хэрэгсэл: Зөөврийн компьютер, диктафон, зургийн аппарат, бусад техник хэрэгсэл

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ

ХЯНАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч

бөгөөд Тэргүүлэх аудитор С.Оюунбилэг

БОЛОВСРУУЛСАН:

Гүйцэтгэлийн аудитын газрын захирал

бөгөөд Тэргүүлэх аудитор М.ДаваанЯм

Аудитын менежер З.Ариунзаяа

Ахлах аудитор Д.Гандолгор

Аудитор М.Туул

Э.Уянга

Н.Эрдэнэбаяр